ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН ШАР ХООЛОЙН ШАВАР БОЛОН ЭЛСНИЙ УУРХАЙН ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5830974

ХҮЛЭЭН АВСАН:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР УУЛ УУРХАЙН ҮНЭЛГЭЭ, НӨХӨН СЭРГЭЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Х.ЭРДЭНЭТӨГС

ТАНИЛЦСАН:

УУРХАЙН ДАРГА Т.ЦЭРЭНДАШ

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭСГИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.БАТСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.БЭХЦЭЦЭГМАА

2025 ОН

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 4
2. ШАР ХООЛОЙН ШАВАР БОЛОН ЭЛСНИЙ УУРХАЙН УУРХАЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ 6
3. УУРХАЙН ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕСС БА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЖЛЫН ГОРИМ 8
4. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ 12
5. ШАВРЫН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН 14
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 15
7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 30
8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 30
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 32
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 38
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 42
12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 48
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ 56
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮГНЭЛТ 57

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбай 7
Зураг 2. Төслийн талбайн координат 7
Зураг 3. Усны машин болон зам усалгааны явц 18
Зураг 4. Батлагдсан технологийн маршрутын зам 18
Зураг 5. Хурдны тайлан 19
Зураг 6. Зам арчилгааны явц болон дараах 19
Зураг 7. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан 20
Зураг 9. Шаврын уурхайн ажиллах хуваарь 21
Зураг 10. Шаврын уурхайн ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт 21
Зураг 11. Усны өдөрлөггийн захирамж, шагналт байр 22
Зураг 12. Усны дээж авах болон Хаанзаа ХХК-р ЦБ үйл ажиллагааг танилцуулсан 23
Зураг 13. Шимт хөрсний хуулалт 23
Зураг 14. Шимт хөрсөөр дотоод овоолгийн дүүргэлт хийж, биологийн нөхөн сэргээлтэнд бэлтгэсэн 24
Зураг 15. Овоолгын хэмжилтийн бүртгэл 25
Зураг 16. Дотоод овоолгын байршлын зураг 25
Зураг 17. Мод тарилалт хийсэн ба мод усалгаа 26
Зураг 18. Засвар үйлчилгээний төв 26
Зураг 19. Засвар үйлчилгээний төв байгаль орчны хяналтын хуудас 26
Зураг 20. Хаягдал тос болон бохирдсон хөрсний саармагжуулалт 27
Зураг 21. Хаягдал поошиг болон асгаралтын иж бүрдэл 27
Зураг 22. 2025 оны уурхайн төлөвлөлт 28
Зураг 23. Наряд зааварчилгааны үеийн зааварчилгаа 28
Зураг 24. Сум орон нутагт өвс хүлээлгэн өгсөн акт 29
Зураг 25. Сум орон нутагт өвс өгсөн 29
Зураг 26. ERP системийн ан амьтны бүртгэл 30
Зураг 27. Олон овоо багийн хогийн цэгийн түрэх, тэгшлэх ажлын эхэн үе 31
Зураг 28. Олон овоо багийн хогийн цэгийн түрч, тэгшилсэн байдал 31
Зураг 29. Олон овоо багийн хогийн цэгийн зардлын тооцоо 32
Зураг 30. Нийт ажилтны сургалтын үе 34
Зураг 31. Нийт ажилтны бүртгэл 34
Зураг 32. Өдөр тутмын зааварчилгаа 35
Зураг 33. Байгаль орчны дотоод хяналт шалгалт 35
Зураг 34. Техникийн үзлэг шалгалтын тайлан 36
Зураг 35. Үйлдвэрийн талбайд байршуулсан галын сарааны үзлэг 37
Зураг 36. Цаг агаарын мэдээ цахимаар илгээсэн 37
Зураг 37. Цаг агаарын 5 хоногийн урьдчилсан мэдээ 37
Зураг 38. Хог хаягдлын сэдвээр анхан шат болон наряд зааварчилгааны сургалт 38
Зураг 39. ERP системийн сургалтын бүртгэл 39
Зураг 40. Шинэ ажилтан болон нийт ажиллтны сургалтын бүртгэл 39
Зураг 41. Хуванцар хаягдлын цуглуулалт 39
Зураг 42. Хуванцар хаягдал нийлүүлсэн баримт 40
Зураг 43. Цэвэрлэгээний үеийн зураг 40
Зураг 44. Цэвэрлэгээний тайлан 41
Зураг 45. Хаягдал поошик болон хаягдал тосны цэг 41
Зураг 46. Шинэ хогийн цэгийн байгууламж /бүтээн байгуулалтын ажил 80 хувьтай/ 42
Зураг 47. Дотооддоо хийсэн тоосны хэмжилтийн тайлан 45
Зураг 48. Ургамлын бичиглэлийн 1 цэг 46
Зураг 49. Ургамлын бичиглэлийн 2-р цэг 46
Зураг 50. Ургамлын бичиглэлийн тайлан 46
Зураг 51. Ургамлын төрөл зүйлийн бүртгэл 47
Зураг 52. ERP системийн ан амьтны бүртгэл 47
Зураг 53. Дуу чимээний хэмжилт 48

Зураг 54. Дуу чимээний хэмжилтийн тайлан 48
Зураг 55. Байгаль орчны сарын постер мэдээ 50
Зураг 56. Наряд зааварчилгааны үеийн сургалтын видео 50
Зураг 57. Газар эзэмших гэрээ 51
Зураг 58. Газар ашигласны төлбөр төлсөн баримт 51
Зураг 59. Ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээ 52
Зураг 60. Усны төлбөр төлсөн баримт 52
Зураг 61. "Даланжаргалан сум" болон" Төвшин сайхан" ХХК-тай байгуулсан гэрээ 53
Зураг 62. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт 53
Зураг 63. Сум орон нутаг 200ш модны суулгац, ургамлын нөөц хамгаалахаар шуудуу ухсан ажлын акт 54
Зураг 64. Малчдын даралт, пүүлс үзсэн 54
Зураг 65. Малчдын худгийн ундаргын хэмжилт 55
Зураг 66. Малчдын санал хүсэлт болон худгийн хэмжилтийн тэмдэглэл 55
Зураг 67. Малчдад өвс хүлээлгэн өгч буй үе 56

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.Уулын ажлын горим 8
Хүснэгт 2. Экскаваторын бүтээлийн тооцоо 9
Хүснэгт 3.Автосамосвалын бүтээлийн тооцоо 9
Хүснэгт 4.CAT-986K Утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо 10
Хүснэгт 5. Хово371 автосамосвалын бүтээлийн тооцоо 10
Хүснэгт 6. CAT-D9GC бульдозерын техникийн тодорхойлолт 11
Хүснэгт 7. CAT-D9GC бульдозерын бүтээ=лийн тооцоо 11
Хүснэгт 8. БОМТ-нд тусгагдсан ажлын биелэлт 14
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 15
Хүснэгт 10. ЦБ-н шинжилгээний хариуны үзүүлэлт 23
Хүснэгт 11. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт 30
Хүснэгт 12. Хогийн цэгийн байршил, зардлын тооцоо 31
Хүснэгт 13. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт 32
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт 38
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт 42
Хүснэгт 16. Усны шинжилгээний хариуны үзүүлэлт 43
Хүснэгт 17. Хөрсний шинжилгээний агрохимийн үзүүлэлт 44
Хүснэгт 18. Хөрсний хүнд металлын үзүүлэлт 44
Хүснэгт 19. Агаарын чанарын хэмжилтийн үзүүлэлт 45
Хүснэгт 20. Дуу шуугианы хэмжилт 47
Хүснэгт 21. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 48
Хүснэгт 22. Нөлөөллийн бүсийн малчдын өвс өгсөн мэдээлэл 55
Хүснэгт 23. БОМТ-ний хэрэгжилтийн биелэлт 56
Хүснэгт 24. БОМТ хэрэгжүүлэх зардлын биелэлт 58

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга: "Монголын Алт" (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг юм. Манай компани уул уурхай, барилгын материалын үйлдвэр, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн

дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.
"Монголын Алт" (МАК) ХХК-ийн Хөх цавын цемент шохойн үйлдвэрийн төсөл болон дагалдах уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 оны 04-р сарын 16-нд "МАК Цемент" ХХК байгуулагдсан.

Компанийн байгаль орчны бодлого:

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах нь компанийн нийт ажиллагсадын нэн тэргүүний зорилт болно.
Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, дүрэм, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл болох учиртай.
Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;
- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах,тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

2. ШАР ХООЛОЙН ШАВАР БОЛОН ЭЛСНИЙ УУРХАЙН УУРХАЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн байршил нь дэд бүтцийн хувьд харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Цомог 4-р багийн нутаг дэвсгэрт орших “Шар хоолой” хэмээх газар байрладаг. Тус байршил нь Улаанбаатар хотоос 310 км, аймгийн төв Сайншанд сумаас 156 км, Даланжаргалан сумын төвөөс хойш 4 км, Олон-Овоо төмөр замын өртөөнөөс зүүн тийш 10 км-ийн зайд оршдог.

Тус орд газарт 2018 онд батлагдсан техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн дагуу жил бүр 400,000 тонн шавар, 15,000 тонн элс олборлох хүчин чадалтай ил уурхай ажиллуулж байгаа бөгөөд элсний олборлолтын хэмжээг өөрчилсөн болон ТЭЗҮ батлагдсанаас хойш таван жил өнгөрсөн тул тодотгол хийх шаардлага үүсч, ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулан 2024 онд батлуулсан байна.

Ордын геологи, уул-геологийн нөхцөл энгийн бөгөөд шаврын давхарга бага гүнд, унал багатайгаар байрласан. Ашиглалтын хувьд 5.0–21.0 м-ийн хооронд зузаантай шаврын үе нь үйлдвэрийн кондицийн шаардлага хангаж, дунджаар 8.0 м-ийн зузаантай нэг түвшнээр олборлоход тохиромжтой гэж үзсэн. Хөрс хуулалтын коэффициент 0.24 м³/тн байгаа нь ил уурхайгаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай нөхцөл бүрдүүлж байна.

Төслийн хүрээнд жил бүр 400,000 тн шавар, 30,000 тн элсийг хуурай аргын цементийн үйлдвэрт бүрэн өөрийн өртгөөр нийлүүлэхээр төлөвлөсөн. Уурхайг сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр тоноглон, тээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын системээр зохион байгуулах бөгөөд олборлолт, тээвэрлэлтэд шаардагдах дэд бүтэц - зам, төмөр зам, эрчим хүч, холбоо зэрэг нь сайтар хөгжсөн. Энэхүү төсөл нь цементийн үйлдвэрийн туслах түүхий эд болох шавар, элсний тогтвортой хангамжийг бүрдүүлэх зорилготой юм.



Зураг 1. Төслийн талбай

№	Түсгай зөвшөөрлийн дугаар	Уртраг			Өргөрөг			Талбайн хэмжээ, га
		град	мин	сек	град	мин	сек	
1	MV-44000039 (2017/001A)	109°	03′	38″	45°	58′	45″	373.22
2		109°	04′	50″	45°	58′	45″	
3		109°	04′	50″	45°	57′	27″	
4		109°	03′	38″	45°	57′	27″	

Зураг 2. Төслийн талбайн координат

Физик газарзүй: Монгол орны ландшафт-экологийн мужлал (Востокова, Гунин, 1995) нь экосистемийг бүрэлдүүлэгч амьгүй хүчин зүйлийн төстэй шинж болон ландшафтын нэгдмэл бүтэц, ургамал, амьтны өвөрмөц онцлогт тулгуурлан зохиогдсон байна. Иймд Монгол орны нутаг дэвсгэрт ялгарах экосистемийг нэг нь нөгөөдөө захирагдах их муж, муж, дэд муж гэсэн 3 шатлалт нэгжийн хүрээнд ангилна. Энэхүү мужлалын хүрээнд 6 их муж, 16 муж, 46 дэд муж ялгасан байна. Энэхүү мужлалаар төслийн талбай нь Төв Азийн заримдаг цөл, цөлийн их мужид хамаарна. Энэ мужийн дэвсгэр нутаг нь платформын хөгжлийн үе шат, тэр дундаа Говийн плитийн хөгжилтэй ихээхэн холбоотой. Говийн плит нь атираат суурьтай ба түүний нам дор хэсгүүд нь 700-800 м хүртэл гүнд шургаж эдгээрт харгалзах хотос хонхор нь дээд цэрдийн ба палеогений насны эх газрын хурдсаар дүүргэгдсэн байдаг. Дээд церд, палеоген насны хурдас нь хэвтээ эсвэл хэвтээд дөхүү чиглэлд тархсан байдаг байна.

Ордын зам харилцаа, дэд бүтэц: Шар болон элсний ордын 50 км-ын радиус дотор Элдэвийн чулуун нүүрсний уурхай, Олон-Овоотын хайрганы үйлдвэр, УБТЗ-ын 25-р зөрлөг, Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний уурхай тус тус оршино. Тус район нь автозам, төмөрзам, өндөр

хүчдэлийн шугамын сүлжээтэй. Уул, уурхайн салбар хөгжих ирээдүйтэй. Районд оршин суугчид нь мал аж ахуй эрхэлдэг.

Ордын байгаль цаг уур: Даланжаргалан сум нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хүйтэн, хуурай урт өвөл, харьцангуй чийглэг богино зунтай. 7 дугаар сарын дундаж температур +25°C, 12 дугаар сарын дундаж температур -21°C хүрдэг. Жилийн дундаж температур нь +4°C орчим байдаг.

Шар хоолойн орд болон түүний ойр орчмын температурын хэмжээг (T2M_RANGE) NASA-гийн GES DISC-ийн MERRA-2 өгөгдлийн9 2021-2024 оны мэдээнд үндэслэн боловсруулсан ба уг өгөгдөл нь өдрийн хамгийн их ба хамгийн бага температурын үнэмлэхүй зөрүүг илэрхийлдэг.

Уурхайн ажлын горим, ажиллах хүч:

ТЭЗҮ болон цементийн үйлдвэрийн хүчин чадал, технологийн горимыг үндэслэн уулын ажлыг төлөвлөж 2025 онд Шар хоолойн шаврын уурхай нь нийт 215.6 мян.м^3 хөрс хуулж, 328.3 мян.тн шаврыг олборлон уриншуулж 162 мян.тн уриншсан шавар, 45.9 мян.тн элс үйлдвэрийн хэрэгцээнд нийлүүлэх зорилтыг биелүүлэхээр ажиллана.

2025 онд Шар хоолойн шаврын уурхайн ажиллах горимыг МАК Цемент ХХК-ын уурхайнуудад мөрдөгдөж буй дараах байдлаар тасралтгүй ажиллагаатайгаар ажиллана. Уулын ажлын горимыг хүснэгт 2-д үзүүлэв.

Хүснэгт 1.Уулын ажлын горим

Д.д	Үзүүлэлт	Хугацаа
1	Ээлжийн тоо	2
2	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12
3	Ээлжин дэх амралт	1
4	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	1
5	Бүтээлтэй ажиллах цаг	10
6	Ээлжийн цаг ашиглалт	0.7
7	Календарийн хоног	365
8	Жилд ажиллах хоног	260

3. УУРХАЙН ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕСС БА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЖЛЫН ГОРИМ

Чулуулгийг ухаж ачихад бэлтгэх процесс

Геологийн тайланд тодорхойлсноор хөрсний чулуулгийн дундаж бат бэх нь проф М.М.Протодьяконовын ангиллаар f<4 СНИП-ын ангиллаар II зэрэгт багтаж байгаа тул механик сийрэгжүүлэлт болон өрөмдлөгө тэсэлгээний ажил хийх шаардлагагүй.

Ухаж ачих процесс

2025 онд 215.6 мян.м^3 хөрсийг автотээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр 3-5 метрийн өндөртэй 2 дэд доголоор 4.6 м3 утгуурын багтаамжтай CAT-374 маркийн экскаваторaар ухаж ачих ажлыг хийж гүйцэтгэнэ. Мөн уурхайгаас цемент шохойн үйлдвэрт 208.2 мян.тн түүхий эдийн ачилтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 2. Экскаваторын бүтээлийн тооцоо

№	Үзүүлэлт	Нэгж	Тоон утга
	Экскаватор		CAT-374
1	Шанаганы багтаамж	$м^3$	4.6
2	Утгуур дүүргэлтийн коэффициент	-	0.8
3	Ухах чулуулгийн хаягдал тооцох коэффициент	-	0.9
4	Операторын ур чадвар тооцох коэффициент	-	0.9
5	Мөчлөгийн хугацаа	сек	33
6	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	-	1.3
7	Цагийн бүтээл	$м^3$	250.8
8	Цаг ашиглалтын коэффициент	-	0.73
9	Мөргөцөг дахь ахилт шилжилтийг тооцох коэффициент	-	0.9
10	Тээврээр хангах нөхцөлийг тооцох коэффициент	-	0.9
11	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
12	Ээлжийн бүтээл	$м^3$	2257.2
13	Ээлжийн тоо	ээлж	2
14	Хоногийн бүтээл	$м^3$	4514.4
15	Техникийн бэлэн байдал тооцох коэффициент	-	0.85
16	Тооцоолоогүй саатлын коэффициент		0.95
17	Сард ажиллах хоногийн тоо		25
18	Сарын бүтээл	$м^3$	112,860
19	Жилийн бүтээл	м3	338,580

Дээрх хүснэгтээс харахад CAT-374 экскаватор бүтээлээр нь тооцон үзэхэд 215.6 мян.$м^3$ хөрс хуулалтын ажил, 328.3 мян. тн шавар, 45.8 мян.тн элс олборлолтын ажилд ажиллахад 1ш экскаваторын бүтээл хүрч байна.

Уурхайн дотоод тээвэр /хөрс болон шавар тээвэрлэлт/

“Шар хоолойн шаврын уурхай” нь 2025 онд хөрс тээвэр шавар тээвэрлэлтийн ажилд CAT-773 маркийн 60тн даацтай автосамосвалаар гүйцэтгэнэ. Хөрсийг дотоод овоолгод байршуулах бөгөөд олборлосон шаврыг шавар уриншуулалтын талбайд буулгаж уриншуулна. Хөрс болон шавар тээвэрлэлтийн дундаж зайг 0.5км-1.2км зайд тээвэрлэхээр тооцов.

Хүснэгт 3.Автосамосвалын бүтээлийн тооцоо

Үзүүлэлт Ажиллах техникийн марк	Хэмжих нэгж	CAT-773
Талын зай	**км**	**1.2**
Ачаатай явах хурд	**км/цаг**	**30**
Хоосон явах хурд	**км/цаг**	**40**
Автосамосвалын даац	**тн**	**60**
Автосамосвалын тэвшний багтаамж	**м3**	**25**
Утгуур дүүргэлтийн коэффициент	**-**	**0.9**
Утгуур дахь сийрэгжилтийн коэффициент	**-**	**1.25**
Чулуулгийн эзэлхүүн жин	**т/м3**	**2.3**
Ачаалах хугацаа	**мин**	**7**
Экскаваторын мөчлөгийн хугацаа	**сек**	**45**

Ачаатай явах	**мин**	**1**
Хоосон явах	**мин**	**1**
Ачаа буулгах хугацаа	**мин**	**0.7**
Сэлгээ хийх хугацаа	**мин**	**1.5**
Автосамосвалын рейсийн хугацаа	**мин**	**11**
Ээлжийн үргэлжлэх хугцаа	**цаг**	**12**
Тэвшний багтаамж ашиглалтын коэффициэнт	**%**	**0.85**
Цагийн бүтээл	**-**	**150**
Ээлжийн бүтээл	**-**	**1200**
Хоногийн бүтээл	**$м^3$**	**2400**
Жилд ажиллах хоногийн тоо	**хоног**	**65**
Жилийн бүтээл	**$м^3$**	**156,000**
Жилд тээвэрлэх уулын цул	**$м^3$**	**283,876**
Шаардлагатай автосамосвал /тооцооний/	**ш**	**2.1**
Шаардлагатай автосамосвал/ бодит/	**ш**	**3**

Дээрх хүснэгтээс харахад хөрс хуулалтын ажил болон шавар олборлолтын ажилд 3 ш CAT-773 автосамосвалаар гүйцэтгэхэд бүрэн боломжтой байна.

Уурхайн уриншсан шавар ачилт болон тээвэрлэлт

2025 онд уриншуулсан 208.2 мян.тн шавар, элсийг цемент шохойн үйлдвэрт тэээвэрлэн нийлүүлнэ. Уриншсан шавар ачилтыг CAT-986K утгуур ачигчаар ачиж Хово-371 маркын автосамосвалаар тээвэрлэхээр тооцов.

Хүснэгт 4.CAT-986K Утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
Утгуурын багтаамж	**$м^3$**	**8.0**
Утгуур дүүргэлтийн коэффициент	**%**	**0.9**
Утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	**%**	**1.4**
Чулуулгийн эзлэхүүн жин	**Тн/м3**	**1.85**
Мөчлөгийн хугацаа	**сек**	**30.0**
Операторын ур чадварыг тооцох коэффициент	**%**	**0.9**
Хаягдлыг тооцох коэффициент	**%**	**0.9**
Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	**%**	**0.8**
Жилд ажиллах хоногийн тоо	**хоног**	**1.1**
Техникийн бэлэн байдлын коэффициент	**%**	**0.9**
Ээлжийн үргэлжлэх хугацаа	**цаг**	**12.0**
Жилд шавар ачих хоногийн тоо	**хоног**	**38**
Утгуурт ачигчийн цагийн бүтээл	**т/цаг**	**1,059**
Утгуурт ачигчийн ээлжийн бүтээл	**т/ээлж**	**7,424**
Утгуурт ачигчийн хоногийн бүтээл	**т/хоног**	**14,848**
Утгуурт ачигчийн жилийн бүтээл	**т/жил**	**3,043,810.54**
Жилд ажиллах хоногийн тоо	**хоног**	**205**
Жилд ачих шаврын хэмжээ	**т**	**210,000**

Дээрх тооцооноос CAT 986K утгуурт ачигч уриншсан шавар ачилтыг бүрэн хангаж ажилллахаар байна.

Хүснэгт 5. Хово371 автосамосвалын бүтээлийн тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар

Хово371 автосамосвал /Шавар тээвэр/				
1	Туулах зай /нэг талдаа/	км	12	L, км
2	Автосамосвалын 1 рейс хийх хугацаа	мин	68.1	Тр=tач+tхөд+tб+tх+tс, мин
3	Автосамосвалын 1 рейс хийхэд тээвэрлэх ачаа	м3	20.7	Vт, нэг рейс тээвэр хийхэд тээвэрлэх хэмжээ
4	Ээлжийн хугацаа	цаг	12	Тээлж
5	Цаг ашиглалт		0.73	Кц
6	Автосамосвалын ээлжийн бүтээл	м3/ээлж	136	Qээлж=60*Тээлж*Vт*Кц/Тр
7	Автосамосвалын хоногийн бүтээл	м3/хоног	272	Qхоног=Qээлж*N
8	Жилд ажиллах хоног	хоног	290	
9	Автосамосвалын жилийн бүтээл	м3/жил	27,890	Qжил=Qсар*N
10	Автосамосвалын жилийн бүтээл	тн/жил	51,597	
11	2023 онд үйлдвэрт шаардлагатай шавар, тн	мян.тн/жил	211	Qш
12	Автосамосвалын тоо	ширхэг	8	Na=Qнийт*1.2/Qжил

Дээрх тооцооноос авч үзвэл уурхайгаас үйлдвэр хүртэл тээвэрлэх уриншсан шавар тээвэрт 8 ширхэг 52 тн автосамосвал ажиллахад бүрэн хангаж ажиллахаар байна.

Овоолгын ажил

2025 онд хуулагдах хөрсийг 8м өндөртэй дотоод овоолго байгуулна. Уурхайн ахилт, уриншуулалтын талбайд өртөх хэсгийн шимт хөрсийг хуулж биологийн нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн урд хэсэгт хийж гүйцэтгэнэ.

2025 онд хөрсийг овоолгод нягтаар 215.2 мян.м^3 байршуулах бөгөөд сийрэгжилт (Кс=1.25) тооцвол 200.7 мян.м^3 хөрс овоолгод хураагдах болно. 2025 оны овоолгын ажлын хэмжээ автосамосвалаар захлах хэлбэрийн овоолго үүсгэж овоолгын ирмэг дээр хөрс асгахад 60% нь овоолгын хажуу руу шууд асгарч, 40% нь овоолго дээр үлдэхээр тооцоход 86.3 мян.м^3 хөрсийг бульдозероор түрж овоолго нээж ажлыг хийнэ.

Уулын ажлын ахилт болон хөрсний гадаад овоолгын ахилт, уриншуулалтын талбайд өртөх 4.2 га талбайн 0.2 м зузаан шимт хөрсийг хуулан шимт хөрсний овоолгод байрлуулна. Нийт 7000м^3 шимт хөрсийг бульдозероор хуулан овоолно.

Хүснэгт 6. CAT-D9GC бульдозерын техникийн тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	CAT-D9R	
	Параметр			
1	Хөдөлгөөний хамгийн их хурд	км/цаг	6,1	
2	Овор хэмжээ	м*м	6.84*4.31	
3	Хөдөлгүүрийн чадал	кВт	302	
4	Хусуурын урт	мм	1934	
5	Өргөлт, буулгалт	мм	606	
6	Жин	тн	18	
7	Хусуурын хамах чадвар	м^3	13.5	

Хүснэгт 7. CAT-D9GC бульдозерын бүтээлийн тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	CAT-D9R
1	Түрэгдэх чулуулгийн бодит эзлэхүүн	м^3	12.8
2	Түрэгдэх призмын паспортын эзлэхүүн	м^3	16
3	Экскавацлалтын хүндрэлийг тооцох коэффициент		0.8

4	Бульдозерын мөчлөгийн хугацаа	сек	90
5	Түрэх зай, налуугаас хамаарсан коэффициент		1
6	Түрэгдэх призм дэх чулуулгийн сийрэгжилтийн коэффициент		1.3
7	Техникийн бүтээл	$м^3$/цаг	367
8	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
9	Цаг ашиглалтын коэффициент		0.65
10	Ашиглалтын бүтээл	$м^3$/ээлж	2862.6
11	Хоногт ажиллах ээлжийн тоо	ш	2
12	Хоногийн бүтээл	$м^3$/хоног	5725.2
13	Сарын бүтээл	$м^3$/сар	160305.6
14	Жилд ажиллах хоног	хоног	120
15	Жилийн бүтээл	$м^3$/жил	687024

Дээрх тооцооноос харахад овоолго дээр CAT-D9GC бульдозер 1 ширхэг 1 ээлжээр ажиллахад 2025 оны овоолгын ажлыг бүрэн хангахаар байна.

4. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Шар хоолойн шавар болон элсний уурхайн ордоос олборлох, тээвэрлэхэд төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2025 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг.

Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:

Гол сөрөг нөлөөллүүд:

- Уурхайн олборлолтын явцад хөрс хуулалт, ачих, тээвэрлэх зэрэг үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх
- Уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан үүсэх
- Ахуйн болон аюултай хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүй тохиолдолд ойр орчмын газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдох
- Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Ил уурхайн гадарга, овоолгууд нь хүчтэй салхи шуурга, аадар борооны улмаас хөрсний сулрал үүсэх, их, бага хэмжээний тоосжилт үүсэх
- Хүнд машин механизм, машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол эрсдэл болох хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ШТМ асгарч, улмаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.
- ШТМ зэрэг хор аюул бүхий бодис материалууд осол эрсдэл, хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас асгарсан тохиолдолд усан орчныг бохирдуулах.
- Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох

Усны чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Төслийн ажилчдын унд ахуй, технологийн хэрэглээнд ус ихээр ашиглах
- Ахуйн бохир ус, хог хаягдлыг ил задгай хаясны улмаас усан орчин бохирдох
- Төслийн үйл ажиллагааны явцад үүссэн химийн бодис, шатах тослох материал нь асгарсан тохиолдолд борооны усны урсац зэргээр дамжин хөрсөнд шингээж, усан орчинг бохирдуулах эрсдэлтэй.

Хөрсний чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:

Гол сөрөг нөлөөллүүд:

- Төслийн үйл ажиллагааны улмаас хөрс, газрын бүрхэвчийн хэв шинж өөрчлөгдөх
- Төслийн үйл ажиллагааны үед машин техник хэрэгслээс шатах тослох материал асгарсан тохиолдолд асгарсан талбайн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.
- Төслийн үйл ажиллагаа болон барилгын ажлын үед хог хаяглал үүсэх, ажилчдын ахуйн хэрэглээнээс ахуйн хатуу хаягдал гарах бөгөөд хог хаягдлыг ил задгай хаясан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох
- Ахуйн болон аюултай хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүй тохиолдолд ойр орчмын газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдох
- Олон салаа зам гаргаснаар хөрсөн бүрхэвч талхлагдах

Ургамлан нөмрөг ба амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:

Гол сөрөг нөлөөллүүд:

- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох
- Төслийн үйл ажиллагаа болон барилгын ажлын үед үржил шимт хөрс хуулагдсанаар уг талбайн ургамлан нөмрөг, хөрсөнд амьдрагч бичил амьтдын амьдрах орчин устах
- Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам гарснаар ургамлан нөмрөг талхлагдах
- Орчны тоосжилтоос үүдэн ургамлын фотосинтезийн бүтээмжид сөргөөр нөлөөлж ургамлын ургах чадварыг багасгах
- Төслийн үйл ажиллагаанд өртсөн газрын хөрсөнд амьдарч буй жижиг мэрэгчид болон шавжийн амьдрах орчин алдагдах
- Төслийн үйл ажиллагааны дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэргийн улмаас амьтад дайжиж үргэх

5. ШАВРЫН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Дорноговь аймгийн Даланжаргалан суманд орших нарны цахилгаан станцын Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр оруулсан.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 8. БОМТ-нд тусгагдсан ажлын биелэлт

д\д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19	19	-
2	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1	1	-
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5	5	
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4	4	
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6	6	
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	7	7	-
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	3	3	-
Нийт		**45**	**45**	-

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
Агаарын чанар					
1	Уурхайн олборлолтын үед үүсэх тоосыг усны машин ашиглаж дарах	Уурхайн ухаш, овоолгууд	11 хоногт 1 удаа буюу сард 2 удаа тээвэрлэлт хийх төлөвлөгөөний дагуу зам усалгаанд нийт 2640 м3 ус ашигласан.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
2	Уурхайн дотоод тээврийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дотоод зам	Дорноговь аймаг Даланжаргалан сумын 4-р багт 15.3км /га/ талбайн газрыг сайжруулсан авто замаар ашиглах зөвшөөрлийг авч, маршрут батлуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
3	Уурхайн дотоод тээврийн зам дагуу ачаатай үед 25-30км/цаг, хоосон үед 35-40км/цагийн хурдны хязгаарлалтыг хийн, хяналтыг тавих	Уурхайн дотоод зам	Хурдны хязгаарыг хянах зорилгоор бүх техникүүдэд GPS суурилуулж тогтмол хяналт тавьж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	7 хоног бүр хурдны хяналт тавих
4	Уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг засаж сайжруулах, нягтаршуулах	Уурхайн дотоод зам	Тээврийн төлөвлөгөөний дагуу CAT16M автогрейдер техникээр технологийн зам арчилгааг хийж ажилласан	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
5	Уурхайн дотоод тээврийн замд бороожуулагч болон бодис ашиглан усалгааг хийх	Уурхайн дотоод зам	Шаврын уурхайн тээвэр тогтмол хийгдэггүй тул бодис турших шаардлага байхгүй. Тээвэрлэлт хийх үед тогтмол усалгааг хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
Усан орчны чанар					
6	Шар хоолойн ордын үйл ажиллагааны үед дараах усны эх үүсврүүдээс зөөвөрлөж унд ахуй, тоосжилт дарах зориулалтаар ус ашиглана. Үүнд: Гүний худаг №1, №2, №3 Хөх Цав худаг ЗҮТ худаг	Төслийн талбай	“МАК Цемент” ХХК-н үйлдвэр, Хөх цавын уурхайн ашиглалтын худгаас ус авч зам усалгаанд ашигладаг. МАК Цемент ХХК болон Хөх цавын уурхайн нь 2025 оны ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг тус тайлант ондоо байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр

7	Дэлхийн усны өдөрлөгөөр уурхайн хүрээнд усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар уурхайн нийт ажилчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах.	Мак Цемент ХХК	Дэлхийн усны өдрийг "Усаа хайрлан хамгаалах, хэмнэлттэй ашиглах дадал бий болгох" уриан дор Даланжаргалан сумын сургуулийн 6-9 ангийн сурагчдын дунд эссэ зохиох болон гар зургын тэмцээн зохион байгуулсан.	1,500,000	Жилд 1 удаа
8	Хаягдал усны тоо хэмжээ, найрлагад хяналт тавьж, шинжилгээ хийлгэх	Мак Цемент ХХК цэвэрлэх байгууламж	"МАК Цемент" ХХК-н үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаас гарч буй бохир усыг Усны газарт ТӨҮГ, Ханлаб ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид MNS 4943:2015 стандартын дагуу бохир усны шинжилгээг 2 удаа хийлгүүлсэн.	2,279,600	Жил бүр
Хөрсөн бүрхэвч					
9	Олборлолт болон бусад үйл ажиллагаа явагдах талбайн шимт хөрсийг зохистой зузаанаар хуулж тусад нь хадгалах	Төслийн талбай	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу шимт хөрс хуулалтыг Монгол Улсын стандарт MNS 5916:2008 стандартын дагуу 20 см гүнтэй хуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
10	Шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгалах ба удаан хадгалсан хөрс сийрэгжих тул хөрсний овоолгуудын дээд болон хажуу гадаргууг хэлбэржүүлэлт хийж, олон наст өвслөг ургамал тарьж, шимт хөрсийг салхинд хийсэн, усанд урсах, бохирдох зэргээс хамгаалах	Хөрсний овоолгууд	Нийт 40474.4м3 хуулсан шимт хөрсийг дотоод овоолгийн дүүргэлт хийж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлтгэж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
11	Хөрсний овоолгуудын талбайн хэмжээ, байршил зэргийг тусган бүртгэл хөтлөх.	Хөрсний овоолгууд	Дотоод овоолгын талбайн хэмжээг тогтмол бүртгэж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
12	Эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх	МАК цемент ХХК үйлдвэрийн бүсэд	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд үйлдвэрийн ногоон бүс нэмэгдүүлэх зорилгоор 4 сараас эхлүүлэн модны тарилтын бэлтгэл ажлыг	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш

			эхлүүлэн 6 байршилд 8 төрлийн 8525 ширхэг мод сөөг тариалсан.		
13	Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тээвэрлэлтийн үед шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих	Төслийн талбай	Машин техникийн засвар үйлчилгээг хатуу хучилттай байгууламжинд хийж хөрсний бохирдол үүсгэхгүйгээр шийдэж ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
14	Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг уурхайн бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах	Зогсоолууд	Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах зориулалтаар асгаралтын иж бүрдлийн засвар үйлчилгээний төвд 2 ширхгийг байршуулж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Эхний жил
Ургамал, амьтан аймаг					
15	Ургамлын мониторинг хийх	Төслийн талбай	ОХШХ-т тусгагдсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр
16	Уурхайн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу гүйцэтгэх, төлөвлөлтийн бус газар хөндөхгүй байх.	Төслийн талбай	2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зураг төслийн дагуу ажлыг гүйцэтгэж ажилласан. Төлөвлөгөөнд тусгагдаагүй газар хөндөгдөөгүй.	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш
17	Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга сануулга өгөх, ургамлын талаарх мэдээллийг нийт ажилтант мэдээлэл түгээх	Төслийн ажилчид	Ээлж эхлэхийн өмнөх наряд зааварчилгаанд маршрутын бус замаар зорчихгүй байхаар ээлжийн ажилчдад зааварчилгааг тогтмол өгч ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа
18	Зуд болон ган гачигтай үед орон нутагт зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ авах зэрэг шаардлагатай өвсийг суманд хүлээлгэн өгөх	Төслийн талбайн ойр орчимд сумын ЗДТГ	Дорноговь аймгийн Даланжаргалан суманд Нийгмийн хариуцлагын хүрээнд байгалийн гамшгийн үед хэрэглэх 200 боодол өвсийг 2025 оны 2 сарын 04-нд ЗДТГазрын захиргаанд хүлээлгэн өгч ажилласан. Жил бүр сум орон нутагтай хамтран ажиллахаар төлөвлөсөн.	2,503,000	Жилд 1 удаа
19	Амьтны бүртгэл хөтлөж ERP дотоод системд оруулан цахимжуулах	Төслийн ажилчид	Тайланд онд төслийн талбайд 2025.06 сард дэлдэн зараа амьтны үзэгдэл бүртгэгдсэн. Ан	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа

			амьтны бүртгэлийг ERP дотоод системд байршуулсан		
Нийт зардал мян.төг				**6,282,600**	

6.1 Уурхайн олборлолтын үед үүсэх тоосыг усны машин ашиглаж дарах

Уурхайн тээвэрлэлттийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулахаар 32 тонн усны белаз 76473 маркийн машинаар зам усалгааг хийж гүйцэтгэсэн. Шаврын уурхайн нөөц бүрдүүлэх ажилтай уялдуулан тээвэрлэлт хийдэг. Шаврын уурхайн Хөх цавын уурхайтай адил тогтмол ажилладаггүй ба 11 хоногт 1 удаа буюу сард 2 удаа тээвэрлэлт хийдэг. Зам усалгаа болон зам арчилгааг тээвэрлэлтийн төлөвлөгөөний дагуу туслах техникүүдийг тус бүр ажиллуулсан. Зам усалгаанд нийт 2640 $м^3$ ус ашигласан.

Зураг 3. Усны машин болон зам усалгааны явц

6.2 Уурхайн дотоод тээврийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх

Монгол улсын газар ашиглах эрхийн 00002648 гэрчилгээний дугаартай, Дорноговь аймаг Даланжаргалан сумын 4-р багт 15.3км /га/ талбайн газрыг сайжруулсан авто замаар ашиглах зөвшөөрлийг авч, үйлдвэр уурхайн зорчих хэсгийн маршрутыг батлуулсан. Маршрутын бус зам, хурдны хязгаарыг бариулах зорилгоор бүх техникүүдэд GPS суурилуулж ажилласан.

Зураг 4. Батлагдсан технологийн маршрутын зам

6.3 Уурхайн дотоод тээврийн зам дагуу ачаатай үед 25-30км/цаг, хоосон үед 35-40км/цагийн хурдны хязгаарлалтыг хийн, хяналтыг тавих

Уурхайн тээврийн маршрутаас олон салаа зам гаргахгүй сумын ЗДТГ-тай зам ашиглах гэрээ хийж, техникүүдийн хурдны хязгаарыг хянах зорилгоор бүх техникүүдэд GPS суурилуулж тогтмол хяналт тавьж ажилласан. Хурдны хязгаар хэтрүүлсэн ажилчдад давтан зааварчилгааны сургалтыг тухай бүрт орсон.



Зураг 5. Хурдны тайлан

6.4 Уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг засаж сайжруулах, нягтаршуулах

Шаврын уурхай нь Хөх цавын уурхайтай адил тогтмол ажилладаггүй ба 11 хоногт 1 удаа буюу сард 2 удаа тээвэрлэлт хийх төлөвлөгөөний дагуу зам усалгаа болон зам арчилгааг CAT16M автогрейдер техникээр хусаж, түрэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Уурхайн технологийн зам болон карьерт хурдны хязгаар, өгсүүр, эргэлт, анхааруулах, туслах зам, тойргийн чиглэл заасан нийт 30 ширхэг тэмдэг тэмдэглэгээ байршуулж ажилласан.

Зураг 6. Зам арчилгааны явц болон дараах

Зураг 7. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан

6.5 Уурхайн дотоод тээврийн замд бороожуулагч болон бодис ашиглан усалгааг хийх

Уурхайн тээвэрлэлт нь тогтмол хийгддэггүй тул бодис турших шаардлагагүй. Тээвэрлэлт хийх үед замын тоосжилт дарах усалгааг тогтмол хийж ажилласан.

6.6 Шар хоолойн ордын үйл ажиллагааны үед дараах усны эх үүсвүүдээс зөөвөрлөж унд ахуй, тоосжилт дарах зориулалтаар ус ашиглана. Гүний худаг 1, 3, Хөх Цав худаг, ЗҮТ-ийн худаг зэргээс худгуудийг тоос дарах, зам талбайн усалгааны хэрэглээнд ашиглана. Ашиглах усны хэмжээгээр ус ашиглах гэрээ байгуулан, ус ашиглах дүгнэлтийг жил бүр гаргуулан ажиллах.

Шаврын уурхайн нөөцийг бүрдүүлэхээр 11 хоногт 1 удаа CAT-986K дугуйт ачигчийг уурхай руу шилжүүлж, 8 ширхэг түрээсийн HOWO-371 автосамосвалаар үйлдвэрийн агуулах руу тээвэрлэлт ажил хийгддэг. 2025 оны ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг Усны газраар гаргуулсан. Шаврын уурхайд усны эх үүсвэр гаргаагүй тул зам усалгаанд “Хөх цавын уурхай”-н ашиглалтын худгаас ус авч зам усалгаанд ашигладаг. Хөх цавын уурхай нь 2025 оны ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг тус тайлант ондоо байгуулсан.

БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТТУЛГА

6/30/2025

Шар хоолойн шавар, элсний уурхайн бүтээл, ажиллах хуваарь

№	Уулын ажлын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Хоногийн бүтээл	Ажиллах хоногийн тоо	Ажиллах техник	Тайлбар
	Олборлолт						
1	Хөрс хуулалт	м3	239,078	5,313	153	4.6м3 , CAT-374E экскаватор 1ш	4-р сарын 1-нээс 8-р сарыг дуустал хөрс хуулалт, шавар, элсний олборлолтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Шавар олборлолт	тн	373,441	4,059			
3	Элс олборлолт		54,102	3,607		60Тн , CAT-773E дамп 3ш	
4	Уулын цул	м3	389,269	2,544			
5	Хөрс хуулалтын итгэлцлүүр	м3/тн		0.56			
	Тээвэр						
6	Цемент үйлдвэрт нийлүүлэлт (Шавар)	тн	162,749	1,345	121	8.5м3, CAT-986K дугуйт ачигч	Тээвэрлэлтийн хувьд 3 хоногт 1 удаа тогтмол явагдах ба үйлдвэрээс дугуйт ачигч шилжиж ажиллана.
7	Цемент үйлдвэрт нийлүүлэлт (Элс)	тн	27,389	226		54тн, Хово-371 автосамосвал	

Шар хоолойн шавар, элсний уурхайг жил өнжиж буюу тэгш тоотой жилүүдэд явуулж 2 жилийн бүтээлийг хангана. Бүтээлийг цементийн үйлдвэр 1 сая.тн цемент үйлдвэрлэх нөхцөлөөр тооцсон. Шавар болон элс тээврийг тогтмол явуулах ба ачилт хийх үед үйлдвэрээс дугуйт ачигч татаж ажилдуулна. Уриншийн талбайг 350мян.тн багтаамжтайгаар төлөвлөсөн. Хөх цавын шохойн чулуун уурхайд 1,2,3,11,12-р саруудад техник шилжиж ажиллана.

ХЯНАСАН : УУРХАЙН ДАРГА: Т.ЦЭРЭНДАШ

ГҮЙЦЭТГЭСЭН : УУЛЫН ИНЖЕНЕР: Г.ДАМДИНСҮРЭН

Зураг 8. Шаврын уурхайн ажиллах хуваарь

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 09 -р сарын 26 -ны өдөр Дугаар Е-2507-000151

1.Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

Байгууллагын нэр: МАК Цемент ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 5830974
Захирал: Батсайхан Баттулга
Холбоо барих утасны дугаар: 75759700

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:

Байгууллагын нэр: Баялаг эко
Холбоо барих утасны дугаар: 80828085

3. Төслийн нэр, байршил:

Төслийн нэр: Шар хоолойн шавар болон элсний ордыг ил аргаар ашиглах төсөл
Байршил: Дорноговь, Даланжаргалан, 4-р баг, Цомог
Харьяалагдах сав газар: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар
Хамаарах салбар: Үүл уурхай

4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

Дугаар	Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт
2017/001А	Тугээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Шар хоолой нэртэй газарт орших 373.22 га талбайд шаврын орд ашиглах зориулалтаар "МАК Цемент" ХХК-д 2017.03.28-ны өдөр 15 жилийн хугацаагаар олгов.
0000142739	Даланжаргалан сумын Засаг даргын 2022.11.22-ны өдрийн А/208 дугаар Захирамжийг үндэслэн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 4-р багийн Биккидийн тал 1 хаягт 3,732,236 м2 газрыг "Уурхайн газар"-ын зориулалтаар эзэмшүүлэхээр "МАК Цемент" ХХК-д 2023.05.25-ны өдөр 5 жилийн хугацаатай олгосон.

5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:

Төслийн хүчин чадал: Шар хоолойн ордоос жилд 400 мян.тн шавар, 30 мян.тн элс олборлож, Хөх цавын цементийн үйлдвэрт нийлүүлэх.
Төслийг хэрэгжүүлэх нийт хугацаа (жил): 10
Ажлын горим: 2 эвлэхээр
Жилд ажиллах хоногийн тоо: 223
Жилд ажиллах хүний тоо: 50

6. Усны нөөц, усны эх үүсвэр:

Эх үүсвэр	Нэр	Зориулалт	Усны нөөц (л/сек)	Усны нөөц (м3/хон)	Байршил (Х, Y)	Тайлбар
Гүний худаг	TS-17/2012 ерөнхий худаг	Технологийн хэрэгцээнд	5.00	432.00	Дорноговь, Даланжаргалан, 3-р баг, Бичигт	Төслийн усны хэрэгцээг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хөх цав гэдэг газарт цементийн үйлдвэрийн усан хангамжийн зориулалтаар гаргуулсан өөрийн эзэмшлийн өрөмдмөл худаг (108°53'18.9", 45°55'45.4")-аас хангана.

7. Төсөлд хэрэглэх, ашиглах усны хэмжээ

Төслийн усны хэрэгцээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм" болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн төсөлд үндэслэн тооцоход:

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр	Нормын хэмжээ	Хэмжих нэгж	Хоногийн хүчин чадал	Тайлбар	Усны хэрэглээ, м3/хон	Жилд ажиллах хоног/тоо	Усны хэрэглээ, м3/жил
Хуйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц	150.0	л	50	Ажилчдын ус хэрэглээ (л/хон)	7.50	223	1,672.50
Гудамж, зам талбай	2.0	л	132723	Тоосжилт дарахад ашиглах ус (л/м2)	265.45	223	59,194.46
Суулгац	40.0	л	400	Мод усалгаанд ашиглах ус (л/ш)	16.00	22	352.00

8. Дүгнэлт:

Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах усны хэрэглээ, м3/хон: 288.95
Усны боломжит нөөц, м3/хон: 432.00
Дүгнэлтийн хариу: хүрэлцээтэй

Зураг 9. Шаврын уурхайн ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт

6.7 Дэлхийн усны өдөрлөгөөр уурхайн хүрээнд усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар уурхайн нийт ажилчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах.

“Мак Цемент” ХХК-ийн Дэлхийн усны өдрийг “Усаа хайрлан хамгаалах, хэмнэлттэй ашиглах дадал бий болгох” уриан дор Даланжаргалан сумын сургуулийн 6-9 ангийн сурагчдын усны талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах, усны ач холбогдлыг сурталчлан таниулах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах дадлыг хэвшүүлэх зорилготой зохион байгуулсан.



БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТТУЛГА

ДЭЛХИЙН УСНЫ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРӨӨЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

2025.03.04

Нэг. Зорилго

"Мак Цемент" ХХК-ийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд Дэлхийн усны өдрийг "Усаа хайрлан хамгаалах, хэмнэлттэй ашиглах дадал бий болгох" уриа дор зохион байгуулж Даланжаргалан сумын сургуулийн 6-9 ангийн сурагчдын усны талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах, усны ач холбогдлыг сурталчлан таниулах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах дадал бий болгох, хэвшүүлэх зориулгатой.

Хоёр. Хэрэгжүүлэх төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хамрах хүрээ	Харицах этэн	Хугацаа
1	"Усаа хэмнэх дадал ба бидний ирээдүй" Эссэ бичгийн уралдаан	6-9 анги	Байгаль орчны инженер	2025.03.10-20
2	"Говийн усыг хайрлан хамгаалах нь бидний оролцоо" Гар зургийн уралдаан			2025.03.10-20
3	"Усны зөв хэрэглээг бусдад эерэгээр түгээцгээе" Видео бичлэгийн уралдаан			2025.03.10-20
4	"Усны менежмент гэж юу вэ?" сургалт орох			2025.03.21
5	"Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ба гадаргын ус" сургалт			2025.03.21

Гурав. Хамрах хүрээ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий Боловсролын Сургуулийн 6-9 дүгээр ангийн нийт сурагчид

Дөрөв. Хүлээн авах хугацаа

2024.03.20-ны 19 цаг хүртэл
Даланжаргалан сумын байгаль орчин С.Дандарбаатар болон
МАК цемент ХХК-ийн Байгаль орчны инженер М.Оюунчимэгт
Видео бичлэгийг: cementecoteam@mak.mn
Фэйсбүүк хаяг: QR кодыг уншуулан илгээж болно.

Усаа хэмнэх дадал ба бидний ирээдүй

Ус бол юугаар ч үнэлээд баршгүй эрдэнэс юм. Гэвч бид усны зохисгүй хэрэглээнээс болж 2050 он гэхэд усны хомсдолд орж магадгүй болоод байна. Үүнийг зогсоохын тулд бид нэгдүгээрт дадал хэвшилд суралцах хэрэгтэй. Яагаад гэвэл амьд организм бүр усгүйгээр оршин тогтнох боломжгүй. Хүний биеийн 60-70 хувийг ус бүрдүүлдэг бол ургамлын эсүүд 90% хүртлээ усаар дүүрэн байдаг. Өдөр тутмын амьдралдаа усыг хэмнэх олон арга зам бий.

Жишээлбэл, шүдээ угаахдаа крантаа хаах, богино хугацаанд шүршүүрт орох, гоожиж буй усны цоргыг засах, аяга таваг угаахдаа усыг хэрэггүй асгахгүй байх гэх мэт жижиг дадлууд ихээхэн ус хэмнэх боломжтой. Мөн ус бага зарцуулдаг ахуйн хэрэглээний хэрэгсэл ашиглах нь усны үр ашигтай хэрэглээг дэмждэг. Энэ бол бидний усаа хайрлаж байгаа маш чухал алхмууд. Гэвч бид энэ үйлдлээ хэдхэн хоног хийчхээд л мартчихдаг, тэгээхээр бид бүгдээрээ ухамсартай хандах хэрэгтэй. Хэрэв тэгж чадвал чи цаанаасаа л өдөр бүр нэг нэг алхмаар дадал хэвшилд суралцаж, ганц ч гэсэн айл өрх усаа хэмнэж ирээдүй хойч үедээ үнэтэй хувь нэмэр оруулах юм.

Хөдөө аж ахуй, аж үйлдвэрт ус хэмнэх нь чухал асуудал юм. Усалгааны ухаалаг систем нэвтрүүлэх, үйлдвэрүүдэд бохирдсон усыг дахин цэвэршүүлэн ашиглах нь усны хэмнэлтэд томоохон хувь нэмэр оруулна. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрт ус хэмнэх нь чухал асуудал юм. Усалгааны ухаалаг систем нэвтрүүлэх, үйлдвэрүүдэд бохирдсон усыг дахин цэвэршүүлэн ашиглах нь усны хэмнэлтэд томоохон хувь нэмэр оруулна. Улс орнууд усны бодлогоо боловсруулж, усыг хайрлан хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь чухал билээ. Ус бол зүгээр л шингэн бус, амьдралын үндэс, байгалийн хамгийн чухал бэлэг юм. Усны үнэ цэнийг ухамсарлаж, хайрлаж, хэмнэж хэрэглэх нь хүн бүрийн үүрэг билээ. Эх дэлхий, байгаль орчноо хамтдаа хамгаалъя.

7б ангийн сурагч Э.Номин Утас: 96400321

№	Уралдааны байр	Монгол дүн, тогрог	Нэрс	Утас	Гарын үсэг
"Усаа хэмнэх дадал ба бидний ирээдүй" Эссэ бичгийн уралдаан					
1	1-р байр	150,000	М.Тодгоолмаа	99880860	Тодгоолмаа
2	2-р байр	100,000	О.Цаллаг	99850561	О.Цаллаг
"Говийн усыг хайрлан хамгаалах нь бидний оролцоо" Гар зургийн уралдаан					
1	1-р байр	150,000	Л.Фрицтунгалаг	88418146	Фрицтунгалаг
2	2-р байр	100,000	Ц.Баатхишиг	8634 3473	Баатхишиг
"Усны зөв хэрэглээг бусдад эерэгээр түгээцгээе" Видео бичлэгийн уралдаан					
1	1-р байр	150,000	Б.Амин-Эрдэнэ	86451209	Амин-Эрдэнэ
2	2-р байр	100,000	Б.Энхнаран	91404081	Энхнаран.

2025.03.21

Зураг 10. Усны өдөрлөггийн захирамж, шагналт байр

6.8 Хаягдал усны тоо хэмжээ, найрлагад хяналт тавьж, шинжилгээ хийлгэх

